

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-6
1.“Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тов тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төсөл	4
2.Дотоод асуудлын талаар	хаалтгай

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо /Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс
нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа
хүндрэлийг шалган тогтоох/-ны 03 дугаар сарын 20-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Б.Бейсен, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар.

Нэг. “Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тов тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Түр хорооны дарга Г.Ганболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Т.Доржханд нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Г.Ганболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа сонсголын товыг хойшлуулах талаар горимын санал гаргав.

Г.Ганболд: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1

Бүгд: 7

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Түр хорооны дарга Г.Ганболд тогтоолын төслийг танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн тавьсан асуултад Түр хорооны дарга Г.Ганболд хариулж, тайлбар хийв.

Г.Ганболд: Горимын санал дэмжигдсэн тул “Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тов тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1

Бүгд: 7

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

85.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дотоод асуудлын талаар

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Түр хорооны дарга Г.Ганболд дотоод асуудлын талаар хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

Г.Ганболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1

Бүгд: 7

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 17 цаг 04 минутад хуралдаан хаалттай горимд шилжив.

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 12 минут үргэлжилж, 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр 17 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТҮР ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
16 цаг 52 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРОО /ХИЛИЙН БООМТУУДААР
АЧАА, ТЭЭВЭР, НҮҮРС НЭВТРҮҮЛЭХ
БОЛОН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД УЧИРЧ БАЙГАА
ХҮНДРЭЛИЙГ ШАЛГАН ТОГТООХ/
НЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР
/ДАВАА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Ганболд: Улсын Их Хурлын гишүүн Одонтуюя, Баттөмөр, Ганболд, Ганбаатар, Ганибал, Доржханд, Энхтүвшин нарын 7 гишүүн хүрэлцэн ирж, ирц 53.8 хувьтай тул хуралдааны ирц хангалттай гэж үзээд хурлыг эхлүүлж байна.

Өнөөдрийн хурлаар 4 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа.

1 дүгээрт нь, Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг товлон зарлах тухай тогтоолын төсөл,

2-т нь, Хянан шалгах түр хорооны хянан шалгах шинжээчдийн ажиллах хугацааг сунгах тухай,

3-т нь, Хянан шалгах түр хорооны тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай,

5-д нь, Хянан шалгах хорооны шинжээч томилох тухай гэсэн ийм 4-т нь, 4 асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу.

Өөр саналтай гишүүд байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнөөдрийн Хянан шалгах хорооны хурал зөвхөн одоо тов зарлах учраас нээлттэйгээр ингээд явчихъя гэж бодож байна.

1 дүгээрт нь, Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 36 дугаар зүйлийн 36.4, 45 дугаар зүйлийн 45.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь гээд ийм тогтоолын төсөл байгаа.

Өнөөдөр бид Их Хурлын дарга мөн Их Хурлын удирдлагуудтай уулзаж ирэх 7 хоногуудын Улсын Их Хурлын чуулганы хуралдаан мөн Байнгын хороодын хуралдаан, заал танхимын хүрэлцээ хангамжийг Их хурлын удирдлагуудтай зөвшилцөөд сонсголыг 23 оны 4 дүгээр сарын 04-нөөс 06-ны өдрүүдэд зохион байгуулахаар товлосон.

Энэ хугацаатай холбогдуулаад гишүүдээс асуух асуулт, саналтай гишүүн байна уу. 4 сарын 04-нөөс 06-ны өдрүүдэд.

Одонтуюя гишүүн.

С.Одонтуюя: Энэ эхний 28, 29, 30 гэдэг нь биш юм байна, тийм ээ. Тэгэхээр би нэг урагшаа Солонгос руу томилолттой байгаа. Тэгээд яг 06-нд ирэх болчхоод байдаг. Энэ 06 гэхдээ юу юм уу, хэд дэх өдөр болчхоод байна. 4 дэх өдөр болчхоод. 06-нд ирэхээр байгаад байдаг. Уг нь яг энэ сонсголд сууя гэж бодсон юм. Бүлгээс тэгээд намайг бол бүр онцгойлон томилсон байгаа шүү дээ. Энэ сонсголд бүр ач холбогдол өгнө шүү. Одонтуюя, Ганибал гээд бид 2 үүрэг авчихсан байж

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

байгаа. Тэгэхээр энэ 06-ныг нэг жоохон хойшлуулж болохгүй юу гээд.

2-т, манай бүлгийн Ганибал гишүүн дараа 7 хоногт томилолттой байгаа. Ганбаатар 2 хоёулаа. Тэгэхээр нөгөө юм хумаа судалж барьж, яах жоохон, тэгэхээр 06-наас жоохон хойшлуулаад өгөөч гэсэн л хүсэлт байгаа юм л даа.

Г.Ганболд: 06 чинь 4 дэх өдөр байгаа л даа. Тэгэхээр бид нар гол нь бас заал танхимын өмнө нь төлөвлөсөн ажлуудаас зөрүүлэх гэж бас 28 энэ тэр гэж байснаа болиод бас өөр өдрүүд, би нэлээн сайн ярьж байж Их Хурлын даргатай ярьж байж энэ чөлөөтэй өдрүүдийг нь бас гаргасан.

Өөр гишүүдээс саналтай гишүүн байна уу. Хугацааны хувьд.

Доржханд гишүүний микрофоныг өгье.

Т.Доржханд: Тэгэхээр парламентын хяналтын сонсгол бол үндсэндээ сөрөг хүчин илүү асуултаа асууж, тэгээд тайлбараа авах ёстой байх. Ялангуяа энэ сонсгол бол сүүлийн 2, 3 жилийн хугацаанд, ковидын үед, тэгээд оптек гэрээтэй холбоотой асуудлууд гээд. Эрх барьж байгаа нам засаглаж байгаа үетэй түлхүү холбогддог болохоор энэ Ардчилсан намын хүсэлтийг дэмжээд явах нь зүйтэй байх аа. Өөрөөр хэлэх юм бол энэ түр хороонд орсон сөрөг хүчний төлөөллүүдээ бүрэн бүрэлдэхүүнтэй байх тэр нөхцөлийг хангаад ажиллавал зөв байх гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Г.Ганболд: Ер нь бол зөв өө. Доржханд гишүүний санал, Одонтуяа гишүүний саналуудыг бас бид хүлээж авах ёстой гэж бодож байна. Тэр дундаа Улсын Их Хурлын энэ цөөнхийн үг, дуу хоолой бол энэ сонсголын үеэр илүү гарах ёстой. Тийм учраас түр хорооны гишүүдийн саналаар бол 06 чинь 4 дэх

өдөр тийм ээ. 7 тав дахь, 8, 9. Тэгэхээр 10-наас 12-ны өдрүүдэд л болох нь дээ. Одонтуяа гишүүн ээ. Болох уу.

Тэгэхээр хугацааны хувьд 4 сарын 10-наас 12-ны өдрүүдэд явуулах нь зүйтэй гэдгээр санал хураалт явуулъя. Одонтуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Би яах вэ, зүгээр Их Хурлын дарга бол би хамгийн гол нь нөгөө тухайн 7 хоногтоо 4 сарын эхний 7 хоногт гэдэг байдлаар ярьсан юм. Бусад 7 хоногууд дээр бол харьцангуй төлөвлөсөн юм байхгүй ээ гэдэг зүйл хэлсэн. Тэгэхдээ би энэ Эрдэнэсамбуу тодруулчих, тэгэх үү. Тодруулсны дараа нь эцэслээд хэдүүлээ санал хураачихъя.

Тэгвэл танхимын хувьд боломжтой юм байна. Гишүүд, санал хураалт. Одонтуяа гишүүний гаргасан горимын саналаар 4 сарын 10-наас 12-эд явуулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 85.7 хувь нь дэмжсэнээр өдрийн хувьд 4 сарын 10-наас 12-ны өдрүүдэд хийх нь зүйтэй гэдгийг дэмжлээ. Ингээд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тогтоол. Нотлох баримтыг шинэчлэн судлах сонсголыг товлон зарлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 36 дугаар зүйлийн 36.4, 45 дугаар зүйлийн 45.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинэчлэн судлах сонсголыг 203 оны 4 дүгээр сарын 10-наас 12-ны өдрүүдэд зохион байгуулахаар товлохуй.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

2. Сонсголын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Хянан шалгах хорооны дарга Ганболдод даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслөөс асуух асуулттай, саналтай гишүүн байна уу.

Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Хугацааны хувьд дэмжсэнд баярлалаа. Одоо сая Хөгжлийн банк чинь хэд хэдэн үе шаттай олон хийчихсэн тийм ээ. Манайх бол тийм байхгүй, энэ 3 хоногоо 1 л үе шат хийгээд л дуусах юм уу. Эсхүл дараа нь дахиад хэд хэд үе шат байх юм болов уу.

Г.Ганболд: Хөгжлийн банкных бол та бүхэн өөрөө мэдэж байгаа. Бүх гэрээ, банкнаас авсан зээлүүдийн гэрээ нь олон мянган гэрээ. Үүнтэй холбогдуулаад олон хоног хийх зайлиггүй шаардлага гарсан юм байна лээ. Бид нар, манай сонсгол бол Хөгжлийн банкны сонсголоос хэлбэрийн хувьд ч тэр, ер нь агуулгын хувьд арай өөр. Энэ агуулгаараа бид нар хянан шалгагч нар, шинжээч нартайгаа урьдчилж хуралдаад ер нь бол манайд ирэх, асуугдах хүмүүс, гэрчээр дуудагдах хүмүүсийн тоо хэмжээ, тухайн асуудлаар хэлэлцэх асуудлууд нь олон хоногоор хийх шаардлагагүй, ер нь 3 хоногт багтаагаад хийхэд нийгэмд энэ сонсголын хийх гэж байгаа бүх мэдээллүүдээ өгчих ийм цаг хугацааны хувьд бүрэн боломжтой гэж урьдчилж дүгнээд ийм байдлаар төлөвлөж байгаа.

Өөр асуулттай гишүүн байна уу. Байхгүй бол тогтоолын төслөө баталъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 85.7 хувь нь дэмжсэнээр тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд Их Хурлын нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2023 оны 4 дүгээр сарын 10-наас 12-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулахаар тогтоолын төсөл батлагдлаа.

17.03 цаг.

Дараагийн асуудлууд нь дотоод ажилтай холбоотой тогтоолын төслүүд байгаа учраас хуралдааныг хаалттайгаар хэлэлцээд явъя гэж ингэж бодож байна. Энд нөгөө шинжээч, хянан шалгагчтай холбоотой асуудал учраас хаалттайгаар хэлэлцээд явъя.

Энэ дээр саналтай гишүүн байна уу.

Хаалттайгаар явуулъя гэдгээр горимын санал оруулж байгаа юм.

Тэгэхээр горимын саналын дагуу дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 85.7 хувь нь дэмжсэн учраас хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.

Хаалттай горимд шилжих бэлтгэл ажил хангана.

Гишүүд 3 минут хүлээх ийм шаардлага гарч байна.

**Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.ОЮУНГЭРЭЛ**